ДАЛАЙВАН АУДИТ
Аудит, баталгаажуулалт, хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

Монгол Улс, Улаанбаатар хот-16066
Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5
Утас: 70005401, 70005404, 70005405
Факс: +976-70005403
Э.Шуудан: info@dalaivanaudit.mn
Вэб хуудас: www.dalaivanaudit.mn

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

**"АРД ДААТГАЛ" ХК -ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД**

## Дүгнэлт

Хураангуй санхүүгийн тайлан нь Ард Даатгал ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ээрх хураангуй санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлого үр дүн, бусад дэлгэрэнгүй орлогын тайлангаас бүрдсэн.

Бидний дүгнэлтээр хавсралт дахь "Ард Даатгал" ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх хураангуй санхүүгийн тайлан нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Аудитлагдсан Санхүүгийн Тайлан, түүний нэмэлт тодруулгатай тохирч байна.

## Санхүүгийн хураангуй тайлан

Энэхүү санхүүгийн хураангуй тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС-ын) шаардсан бүх тодруулгыг агуулаагүй болно. Иймд энэхүү санхүүгийн хураангуй тайлан нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан даатгалын компанийн нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу илэрхийлэгдсэн аудитлагдсан санхүүгийн тайланг орлохгүй.

## Аудитлагдсан санхүүгийн тайлан ба бидний дүгнэлт

Бид 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон компанийн санхүүгийн тайланд хязгаарлалтгүй санал дүгнэлт өгсөн. Уг тайланд аудитын гол асуудал асуудлын талаарх мэдээллийг тусгасан. Аудитын гол асуудал нь бидний мэргэжлийн үнэлэмжээр хамгийн чухал асуудал байдаг.

## Хураангуй тайлангийн талаар удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан журмын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, түүндээ үндэслэн хураангуй санхүүгийн тайлангаа үнэн зөв бэлтгэх, тайлагнах үүрэгтэй .

## Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Компаний бэлтгэсэн хураангуй санхүүгийн тайлан нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд аудитлагдсан санхүүгийн тайлантай тохирч байгаа эсэхийг шалгах, АОУС 810 буюу "Хураангуй санхүүгийн тайлангийн талаар тайлагнах гэрээт ажлууд"-аар шаардсан горимуудыг гүйцэтгэж дүгнэлт өгөх явдал юм.

ДАЛАЙВАН АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

2020 ОНЫ 02 ДУГААР
САРЫН 18-НЫ ӨДӨР

bakertilly
INTERNATIONAL

**АРД ДААТГАЛ ХК**

**2019 оны 12 дугаар сарын 31-ээрх хураангуй санхүүгийн байдлын тайлан**

| | 2019.12.31. мянган төгрөгөөр | 2018.12.31. мянган төгрөгөөр |
|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 422,095.4 | 315,828.3 |
| Хөрөнгө оруулалт | 15,179,496.5 | 14,371,951.3 |
| Даатгалын авлага | 755,867.9 | 1,177,362.8 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 1,129,819.0 | 1,388,860.6 |
| Бусад санхүүгийн бус хөрөнгө | 611,568.4 | 502,072.0 |
| Даатгалын хөрөнгө | 1,514,608.1 | 2,117,279.1 |
| Өмч, барилга, тоног төхөөрөмж -цэвэр | 1,036,617.2 | 1,129,789.2 |
| Биет бус хөрөнгө | 173,590.1 | |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **20,823,662.6** | **21,003,143.3** |
| **ӨР ТӨЛБӨР** | | |
| Даатгалын өр төлбөр | 699,938.1 | 1,315,097.4 |
| Бусад санхүүгийн өр төлбөр | 109,277.6 | 350,174.0 |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | 329,298.8 | 148,682.8 |
| Орлогод тооцоогүй хураамжийн нөөц | 4,875,238.2 | 6,178,177.5 |
| Учирсан боловч мэдэгдээгүй ХНС | 1,082,321.6 | 931,487.4 |
| Мэдсэн боловч төлөөгүй ХНС | 335,203.1 | 103,592.5 |
| Учирч болзошгүй ХНС | 946,122.9 | 615,268.5 |
| Тусгай нөөц сан | 641,252.8 | 641,252.8 |
| **Нийт нөөц сан** | **7,880,138.6** | **8,469,778.6** |
| **Нийт өр төлбөр** | **9,018,653.1** | **10,283,732.9** |
| **Өөрийн хөрөнгө** | | |
| Энгийн хувьцаа | 5,000,000.0 | 5,000,000.0 |
| Нэмж төлөгдсөн капитал | 3,280,854.5 | 3,280,854.5 |
| Хуримтлагдсан ашиг | 3,524,155.0 | 2,438,556.0 |
| **Нийт өөрийн хөрөнгө** | **11,805,009.5** | **10,719,410.5** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | **20,823,662.6** | **21,003,143.3** |

**2019 оны 12 дугаар сарын 31-ээрх хураангуй орлого үр дүнгийн тайлан**

| | 2019 мян.төг | 2018 мян.төг |
|---|---|---|
| **Даатгалын үйл ажиллагаа** | | |
| Даатгалын хураамжийн цэвэр орлого | **8,896,130.4** | **9,609,438.2** |
| Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт | 1,302,939.2 | (2,283,234.0) |
| Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт | (575,265.1) | 749,049.4 |
| **Орлогод тооцсон хураамж** | **9,623,804.5** | **8,075,253.6** |
| **Нөхөн төлбөрийн цэвэр зардал** | **(3,848,740.7)** | **(3,487,866.1)** |
| Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт | (382,444.8) | (473,757.2) |
| Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт | 125,658.5 | (16,645.1) |
| Учирч болзошгүй хохирлын нөөцийн сангийн өөрчлөлт | (330,854.4) | (153,195.5) |
| **Зардалд тооцсон нөхөн төлбөр** | **(4,436,381.4)** | **(4,131,464.0)** |
| Даатгалын гэрээний зардал | (1,953,933.1) | (1,441,187.6) |
| Давхар даатгалын шимтгэлийн орлого | 180,383.2 | 116,864.3 |
| Хөрөнгө оруулалтын олз, гарз | 2,410,782.4 | 1,756,925.5 |
| **Даатгалын үйл ажиллагааны ашиг/(алдагдал)** | **5,824,655.6** | **4,376,391.8** |
| Бусад ашиг/(алдагдал) | (3,823,966.3) | (2,989,585.2) |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг/(алдагдал)** | **2,000,689.3** | **1,386,806.7** |
| Орлогын албан татварын зардал | (281,940.2) | (123,403.2) |
| **Татварын дараах ашиг/(алдагдал)** | **1,718,749.0** | **1,263,403.5** |
| **Нэгж хувьцаанд ногдох ашиг-төгрөгөөр** | **68.75** | **65.16** |

"BALAIVAN AUDIT" Co.,Ltd
CERTIFIED ACCOUNTING, AUDITING & APPRAISAL